

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Даатгалын багц дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн есдүгээр хавсралт “Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага”-д энэ тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан агуулга бүхий 1 дүгээр хавсралтыг, “Даатгалын багц дүрэм”-ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-т энэ тогтоолын хоёрдугаар хавсралтад заасан агуулга бүхий 40 дүгээр хавсралт (Б)-ыг тус тус нэмсүгэй.

2.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2.3.6, 2.4.3.6.и, 2.4.3.7, 2.4.6.5, 2.4.4.8, 2.4.4.9, 2.6.4.9, 2.6.4.10, 2.6.4.11, 3.4.8, 3.4.9, 6.1.2.2.а, 6.1.2.2.б, 6.1.2.2.в, 6.1.2.2.г, 6.1.2.3, 6.1.2.4, 6.1.2.5, 6.1.13.3, 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.10, 7.11, 7.12, 7.13 дахь заалт, 5 дугаар хавсралтын “Маягт нөхөх заавар:” хэсгийн 3, 4, 5 дахь заавар, “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 4.2.4 дэх заалтыг доор дурдсан агуулгаар тус тус нэмсүгэй:

1/ “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2.3.6, 2.4.3.6.и, 2.4.3.7, 2.4.6.5, 2.4.4.8, 2.4.4.9, 2.6.4.9, 2.6.4.10, 2.6.4.11, 3.4.8, 3.4.9, 6.1.2.2.а, 6.1.2.2.б, 6.1.2.2.в, 6.1.2.2.г, 6.1.2.3, 6.1.2.4, 6.1.2.5, 6.1.13.3, 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.10, 7.11, 7.12, 7.13 дахь заалт, 5 дугаар хавсралтын “Маягт нөхөх заавар:” хэсгийн 3, 4, 5 дахь заавар:

“2.3.6.Даатгагч нь даатгалын зуучлагчаар дамжуулан даатгалын гэрээг байгуулах нөхцөлд Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 8.1.2-т заасан даатгалын

зуучлагч, эсхүл тус хуулийн 13.1-д заасан зөвшөөрлийг авсан гадаадын даатгалын зуучлагчтай хамтран ажиллана.”

“2.4.3.6.и.Хорооноос шаардсан бусад.”

“2.4.3.7.даатгалын нөхөн төлбөрийн шийдвэрийн хугацаа, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хагас жил тутам нөхөн төлбөрийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ.”

“2.4.4.8.байгаль орчин, нийгэм засаглал /БОНЗ/-ын тайланг гаргаж, ТУЗ-аар батлуулан жил бүрийн 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ;”

“2.4.4.9.даатгалын гэрээний дагуу даатгуулагчид учирч болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, энэ чиглэлээр гарах зардлыг холбогдох төлөвлөгөөнд тусгах.”

“2.4.6.5.Даатгалын тухай хуулийн 17.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд даатгагч нэн тэргүүнд даатгалын эрсдэлийг хамтран даатгах саналыг бусад даатгагчид тавьж, хамтын даатгалаар эрсдэлийг даатгах боломжийг бүрдүүлнэ.”

“2.6.4.9.“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайлан /хамгийн сүүлийн/;”

“2.6.4.10.даатгалын төлөөлөгчийн нэрс, байршил /Хорооноос тусгай зөвшөөрөлтэй, даатгалын компанийг төлөөлөх даатгалын төлөөлөгч/;”

“2.6.4.11.даатгагчийн цахим хуудсанд байршуулахаар Даатгалын хууль тогтоомжид заасан бусад мэдээллүүд.”

“3.4.8.даатгалын зуучлагч нь зөвхөн гуравдагч этгээдийн хөрөнгө, амь нас, ашиг сонирхлыг зуучлах бөгөөд даатгалын зүйлд даатгуулах ашиг сонирхол бүхий байх тохиолдолд даатгалын хураамжийн орлогоос борлуулалтын хувь, шагнал хүртэхгүй.”

“3.4.9.даатгалын зуучлагч нь даатгуулагчид даатгагчийг сонгох боломжоор хангаж ажиллана.”

“6.1.2.2.а.даатгалын үнэлгээг гэрээ байгуулах үед даатгуулагчтай хэлэлцэн тохирч байгуулах зарчмыг хэрэгжүүлэх ба нэгэнт хэлэлцэн тохирсон тохиолдолд нөхөн төлбөр олгохдоо хохирлыг даатгалын үнэлгээнд харьцуулж хувь тэнцүүлэхгүй байх;”

“6.1.2.2.б.даатгалын хохирлыг үнэлэхэд баримтлах суурь /зах зээлийн үнэлгээ эсвэл орлуулан солих үнэлгээний суурь/ элэгдэл тооцох эсэх зэрэг нөхөн төлбөрөөс хасч тооцох нөхцөлийг тусгайлан заах;”

“6.1.2.2.в.даатгалын гэрээний нөхөн төлбөр олгохгүй нөхцөл нь даатгасан эрсдэлтэй зөрчилдөөгүй байх, даатгах үйлчилгээний зорилгоо үгүйсгээгүй байх, далд, хоёрдмол утгаар илэрхийлээгүй байх;”

“6.1.2.2.г.даатгалын нөхөн төлбөр олгоход бүрдүүлэх баримт материалд олж авах боломжгүй, хэрэгжүүлэх боломжгүй заалт оруулахгүй байх;”

“6.1.2.3.даатгагч даатгалын гэрээгээр заасан хугацаанд даатгалын нөхөн төлбөрийг олгоогүй тохиолдолд даатгуулагчид учрах хохирлыг хэрхэн төлөх талаарх зохицуулалтыг даатгалын гэрээнд тусгана.”

“6.1.2.4.Иргэний хуулийн 200.1 дэх хэсэгт заасан стандарт нөхцөл бүхий гэрээний хувьд тус хуулийн 202 дугаар зүйлд заасан стандарт нөхцөл хүчин төгөлдөр бус болох нөхцөлийг тусгахгүй байх;”

“6.1.2.5.мэргэжлийн нэр томъёоноос зайлсхийх, хэрэв оруулсан бол ойлгомжтой, энгийн байдлаар тайлбарлах.”

“6.1.13.3.үндсэн эрсдэл учрах шалтгаан, нөхцөлийг Өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу ангилан, даатгуулагч сонголт хийх боломжтой байдлаар даатгалын бүтээгдэхүүн боловсруулагдсан байх.”

“7.1.1.нарийн техникийн маргаан гаргахаас зайлсхийх буюу хэт нарийн, хэтрүүлэн шалгахгүй байх;”

“7.1.2.даатгагч нь даатгалын нөхөн төлбөрийг шийдвэрлэхэд шаардлагагүй буюу тухайн даатгалын тохиолдолтой шууд холбоо хамааралгүй, ач холбогдолгүй, олж авахад бэрхшээлтэй, хүндрэлтэй бичиг баримт шаардахгүй байх;”

“7.1.3.даатгагч энэ журмын 7.1.2 дахь заалт болон буруутай этгээд тогтоогдоогүй байгаа гэх шалтгаанаар даатгалын нөхөн төлбөрийг хойшлуулах, татгалзах, зайлхийх үйлдэл гаргахгүй байх;”

“7.1.4.даатгагч гэрээний нөхөн төлбөр олгохгүй хэсэгт заагдсан нөхцөл байдал үүссэнийг баримтаар нотолж чадахгүй бол нөхөн төлбөрийг бүрэн болон хэсэгчлэн олгохоос татгалзахгүй байх;”

“7.1.5.даатгагч даатгалын гэрээгээр заасан хугацаанд даатгалын нөхөн төлбөрийг олгоогүй тохиолдолд учрах хохирлыг барагдуулах талаарх даатгалын гэрээнд тусгагдсан нөхөн төлбөрийг даатгуулагчид олгоно.”

“7.10.Даатгагч даатгалын нэхэмжлэлийн дуудлагыг хүлээн авах, даатгалын хохирлыг баталгаажуулах, хохирлыг бууруулах арга хэмжээ болон даатгалын нөхөн төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн зааварчилгааг өгөх 24/7 ажилладаг нэгдсэн нэг дугаартай байх бөгөөд даатгуулагч аль ч цагт хялбар байдлаар холбогдох боломж нөхцөлөөр хангасан байна. Даатгагч энэ мэдээлэл өөрчлөгдсөн тухай бүр ажлын 3 өдрийн дотор бичгээр, эсхүл цахимаар Хороонд ирүүлнэ.”

“7.11.Даатгагч нь иргэдийн даатгалын гэрээнд хамаарах даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаанд энэ журмын 6.2.2.3-т заасан асуулгын маягтад дурдсанаас өөр нөхцөлийг ашиглахгүй.”

“7.12.Даатгалын тохиолдолд даатгуулагч, түүний ажилтан, даатгалын зүйлд нэгдмэл ашиг сонирхол бүхий этгээд буруутай байх тохиолдолд даатгагч олгосон нөхөн төлбөрийг эргүүлэн нэхэмжлэхгүй байна. Даатгалын тохиолдлыг санаатайгаар бий болгосон, гэмт хэрэг, шунахайн сэдлээр хохирол учруулсан, мансуурах, согтуурах үйлдлийн үр дагаварт бий болгосон тохиолдол энэхүү нөхцөлд үл хамаарна.”

“7.13.Даатгалын тохиолдолд гуравдагч этгээд буруутай байх тохиолдолд уг этгээд хохирлыг төлөх хэлцэлд орохгүй байх, баталгаа өгөхгүй байх нөхцөлд даатгагч нөхөн төлбөр төлөх үүргээ биелүүлэхгүй байх, хойшлуулах, зайлсхийх үйлдэл гаргахгүй байна.”

“3.Багана "2"-т тайлангийн үед даатгалын тохиолдол нь учирсан бөгөөд нэхэмжилсэн эсэхээс үл хамааран даатгагч мэдсэн даатгалын өр төлбөрийн дүн, тэдгээрт холбогдох хохирол үнэлгээ, шинжээчийн зардлын дүнг бичнэ.”

“4.Багана "3"-т тайлангийн хугацаанд барагдуулсан нэхэмжлэлийн дүнг бичнэ.”

“5.Багана "6", "7"-д багана "2", "3"-т тусгасан нэхэмжлэл болон барагдуулсан нэхэмжлэлийн давхар даатгагчид ногдох дүнг бичнэ.”

2/ “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 4.2.4 дэх заалт:

“4.2.4.Энэ журмын 4.1.3-т заасан төлөвлөгөөг даатгагчийн Төлөөлөн удирдах зөвлөл баталсан байна.”

3.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 6.1.5 дахь хэсгийн “... байна.” гэсний дараа “Үүнд: хариуцах ажилтан, тэдгээрийн чиг үүрэг, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага болон үйл ажиллагааны дарааллыг нарийвчлан тодорхой тусгасан байна.”, 7.3 дахь хэсгийн “даатгалын хураамжийг” гэсний дараа “даатгагч гэрээний дагуу нөхөн төлбөрийг олгох ба” гэж тус тус нэмсүгэй.

4.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 6 дугаар хавсралт (А)-ыг энэ тогтоолын гуравдугаар хавсралт, “Даатгалын багц дүрэм”-ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 31 дүгээр хавсралтыг энэ тогтоолын дөрөвдүгээр хавсралт, “Даатгалын багц дүрэм”-ийн арван хоёрдугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах

шаардлага”-ын 1 болон 2 дугаар хавсралтыг энэ тогтоолын тавдугаар хавсралтад заасан агуулгаар тус тус өөрчлөн найруулсугай.

5.Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2.4.3.6.3, 2.6.4, 2.6.4.4, 2.6.4.5, 4.3, 4.3.4.1, 6.1.2.2, 6.2.3.9, 7.1 дэх заалт, 4 дүгээр хавсралтын “Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл” хэсэг, “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 4.2 дахь заалт, “Даатгалын багц дүрэм”-ийн есдүгээр хавсралт “Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага”-ын 2.1 дэх заалт, “Даатгалын багц дүрэм”-ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 2.1, 2.1.1, 2.1.2, 2.12 дахь заалт болон 40 дүгээр хавсралтаар баталсан маягтын нэрийг доор дурдсан агуулгаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2.4.3.6.3, 2.6.4, 2.6.4.4, 2.6.4.5, 4.3, 4.3.4.1, 6.1.2.2, 6.2.3.9, 7.1 дэх заалт болон 4 дүгээр хавсралтын “Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл” хэсэг:

“2.4.3.6.3.тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм засаглал /БОНЗ/-ын чиглэлээр хэрэгжүүлэх ажлын бодлого, зорилго, жил бүрийн төлөвлөгөө;”

“2.6.4.Даатгагч нь дараах мэдээллийг заавал агуулсан өөрийн цахим хуудастай байх ба хамгийн сүүлийн үеийн байдлаар мэдээллийг тухай бүр шинэчилсэн байна:”

“2.6.4.4.Өргөдөл гомдол шийдвэрлэлт /Ирүүлсэн өргөдөл гомдол, шийдвэрлэсэн өргөдөл гомдол, шүүхийн шатанд явж байгаа өргөдөл гомдлын мэдээ, өргөдөл гомдолтой холбоотой Хорооны шийдвэрийн хэрэгжилт/;”

“2.6.4.5.Даатгалын бүтээгдэхүүний цахим мэдэгдэл, маягт, дэлгэрэнгүй танилцуулга /даатгалын эрсдэл, хураамж, үнэлгээ, нөхөн төлбөр, нөхөн төлбөр олгох олгохгүй нөхцөл зэргийг тусгасан/;”

“4.3.Даатгалын хохирол үнэлэгч нь Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 14.1-д заасан тусгай зөвшөөрлийг авсан байх бөгөөд үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдох дараах шаардлагыг хангаж ажиллана.”

“4.3.4.1.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 15.1-д заасан эрх авсан хоёроос доошгүй үнэлгээчинтэй байх;”

“6.1.2.2.даатгалын гэрээнд даатгагч, даатгуулагчийн эрх үүрэг, даатгалын эрсдэл, даатгалын үнэлгээ, гэрээний эхлэх дуусах хугацаа, гэрээг сунгах, цуцлах, өөрчлөлт оруулах нөхцөл, даатгалын хураамжийн хэмжээ, хураамж төлөх хугацаа, даатгалын хураамж буцаах нөхцөл, даатгалын гэрээ ямар нөхцөлд хүчин төгөлдөр бус болох, нөхөн төлбөр олгохоос татгалзах заалт зэргийг тодорхой зааж тусгасан байх бөгөөд дараах шаардлага тавигдана:”

“6.2.3.9.даатгалын тохиолдол болох үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан заавар, даатгалын нөхөн төлбөр олгох нөхцөл, нөхөн төлбөр авах үйл ажиллагааны тодорхой дараалал болон энэ талаар мэдээлэл өгөх утас, холбогдох хаягийн мэдээлэл.”

“7.1.Даатгагч даатгалын нөхөн төлбөр олгоходоо даатгуулагчид хүндрэл учруулахгүй, шуурхай олгох зарчмыг баримтлах бөгөөд дараах нийтлэг шаардлага тавигдана:”

“Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл: Даатгалын үндсэн эрсдэл/бенефит”

2/ “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 4.2 дахь заалт:

“4.2.Энэ журмын 4.1.2, 4.1.3-т заасан төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:”

3/ “Даатгалын багц дүрэм”-ийн есдүгээр хавсралт “Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага”-ын 2.1 дэх заалт:

“2.1.Гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогч нь Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газар нээх, татан буулгах, өөрчлөн байгуулах, удирдлага болон хаяг өөрчлөгдөх тухай бүр энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан мэдээллийг Хороонд ирүүлэх бөгөөд дараах шаардлагыг хангаж ажиллана:”

4/ “Даатгалын багц дүрэм”-ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 2.1, 2.1.1, 2.1.2, 2.1.2 дахь заалт болон 40 дүгээр хавсралтаар баталсан маягтын нэр:

“2.1.Даатгагч болон даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч (цаашид “даатгалын байгууллага” гэх) нь санхүүгийн нэмэлт тайланг улирал бүр гаргаж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д заасан санхүүгийн тайлангийн хамт эхний хагас жилийн болон жилийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд, 1 болон 3 дугаар улирлын санхүүгийн тайланг дараа

улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор дараах хэлбэрээр Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нд ирүүлнэ:”

“2.1.1. Даатгагч нь цаасаар болон Хорооны цахим бүртгэл (Фина программ)-д;”

“2.1.2. Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нь эхний хагас жилийн болон жилийн санхүүгийн тайланг цаасаар болон Хорооны цахим бүртгэл (Фина программ)-д, 1 болон 3 дугаар улирлын санхүүгийн тайланг зөвхөн Хорооны цахим бүртгэл (Фина программ)-д илгээх.”

“2.12. Ердийн болон давхар даатгагч нь даатгалын үйл ажиллагаатай холбогдсон товч мэдээллийг энэ зааврын 40 дүгээр хавсралт, урт хугацааны даатгагч нь даатгалын үйл ажиллагаатай холбогдсон товч мэдээллийг энэ зааврын 40 дүгээр хавсралт (Б) дагуу тус тус дараа сарын 10-ны өдрийн дотор цахим хэлбэрээр ирүүлнэ.”

“МАЯГТ СЗХ04201А.ЕРДИЙН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН”

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 2.8.14 дэх заалтын “улирал бүр” гэснийг “жилд 2 удаа” гэж, “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 3.11 дэх заалтын “3.7-д” гэснийг “3.4-т” гэж, дугаарлалтын “3.3” гэснийг “3.2.10”, “3.4” гэснийг “3.2.11”, “3.5” гэснийг “3.2.12”, “3.6” гэснийг “3.3”, “3.7” гэснийг “3.4”, “3.8” гэснийг “3.5”, “3.9” гэснийг “3.6”, “3.10” гэснийг “3.7”, “3.11” гэснийг “3.8”, “3.12” гэснийг “3.9”, “3.13” гэснийг “3.10” гэж, “Даатгалын багц дүрэм”-ийн есдүгээр хавсралт “Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах нөхцөл, шаардлага”-ын дугаарлалтын “2.3” гэснийг “2.2” гэж, “Даатгалын багц дүрэм”-ийн арван хоёрдугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын 2.2.7.3 дахь заалтын “2.7.2.1” гэснийг “2.2.7.1” гэж тус тус өөрчилсүгэй.

7. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 6.1.13 дахь заалтын “аливаа шалтгааны улмаас”, “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 4.1.2 дахь заалтын “бөгөөд шаардлагатай тохиолдолд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх” гэснийг, “Даатгалын багц дүрэм”-ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн

оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 2.1.3, 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус хассугай.

8.“Даатгалын багц дүрэм”-ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 2.13 дахь заалт, мөн тус хавсралтын 41 дүгээр хавсралт “МАЯГТ СЗХ04202.ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН”, 42 дугаар хавсралт “МАЯГТ СЗХ04203.ДААТГАЛЫН ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

9.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны ... дугаар сарын
...-ны өдрийн ... дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

“Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан
даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах
гадаадын даатгагч, гадаадын даатгалын мэргэжлийн оролцогчид
тавигдах нөхцөл, шаардлага”-ын 1 дүгээр хавсралт

**Салбар, төлөөлөгчийн газар нээх, түүнийг татан буулгах, өөрчлөн байгуулах болон
салбар, төлөөлөгчийн газрын удирдлага, хаягийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл**

1	Огноо	Он		Сар		Өдөр	
2	Мэдээлэл гаргагчийн төрөл	<input type="checkbox"/> Гадаадын даатгагч <input type="checkbox"/> Гадаадын даатгалын зуучлагч <input type="checkbox"/> Гадаадын даатгалын хохирол үнэлэгч					
3	Гадаадын даатгалын байгууллагын оноосон нэр					
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
4	<input type="checkbox"/> Салбар, төлөөлөгчийн газар нээх, түүнийг татан буулгах, өөрчлөн байгуулах (5-7-р хэсгийг бөглөх) <input type="checkbox"/> Салбар төлөөлөгчийн газрын удирдлагын өөрчлөлт (8-г бөглөх) <input type="checkbox"/> Салбар төлөөлөгчийн газрын хаягийн өөрчлөлт (9-г бөглөх)						
Салбар, төлөөлөгчийн газар нээх							
5	Салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр:						
	Салбар, төлөөлөгчийн газрын удирдлага (овог, нэр)					
	Салбар, төлөөлөгчийн газрын албан ёсны хаяг, байршил:						
	Салбар, төлөөлөгчийн газрын холбоо барих утасны дугаар:						
Салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах тохиолдолд							
6	Салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр:	Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар			
Салбар, төлөөлөгчийн газрыг өөрчлөн байгуулах							
7	Салбар, төлөөлөгчийн газрыг өөрчлөн байгуулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр:	Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар			
Салбар, төлөөлөгчийн газрын удирдлагын өөрчлөлт							

8	Шинэ удирдлага томилогдсон тухай эрх бүхий этгээдийн шийдвэр	Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар
	Шинэ удирдлага	Овог		Нэр
Салбар төлөөлөгчийн газрын хаягийн өөрчлөлт				
9	Хуучин хаяг:	Шинэ хаяг:		
		
		

Компанийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Даатгалын багц дүрэмд нийцүүлэн мэдээллийг үнэн зөв бөглөж, хүргүүлэв. Дээрх мэдээлэлд ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Мэдээлэл гаргасан:

Овог, нэр

албан тушаал

гарын үсэг

огноо

Тамга:

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны ... дугаар сарын
...-ны өдрийн ... дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн
оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах
заавар”-ын 40 дүгээр хавсралт (Б)

**МАЯГТ СЗХ04201Б.УРТ ХУГАЦААНЫ ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТОВЧ ТАЙЛАН**

Даатгалын компани.....

..... оны ... сарын ...-ны өдөр

№	Үзүүлэлт	Тухайн сарын дүн	Өссөн дүнгээр
1	Нийт хөрөнгийн дүн (төгрөгөөр)		
2	Нийт өр төлбөрийн дүн (төгрөгөөр)		
3	Даатгалын нөөц сан (төгрөгөөр)		
4	Хувь оролцоотой гэрээний нөөц сан		
5	Хувь оролцоогүй гэрээний нөөц сан		
6	Хөрөнгө оруулалттай холбоотой гэрээний нөөц сан		
7	Даатгалын нийт үнэлгээ (төгрөгөөр)		
8	Давхар даатгалд шилжүүлсэн даатгалын үнэлгээ (төгрөгөөр)		
9	Даатгалын нийт хураамж (төгрөгөөр)		
10	Үүнээс: Ипотекийн даатгалын хураамж (төгрөгөөр)		
11	Давхар даатгалд төлсөн хураамж (төгрөгөөр)		
12	Олгосон нийт нөхөн төлбөр (төгрөгөөр)		
13	Үүнээс: Ипотекийн даатгалын нөхөн төлбөр (төгрөгөөр)		
14	Давхар даатгалаар төлүүлсэн нөхөн төлбөр (төгрөгөөр)		
15	Байгуулсан даатгалын гэрээний тоо		
16	Үүнээс: Ипотекийн даатгалын гэрээний тоо		
17	Ипотекийн даатгалд хамрагдсан даатгуулагчийн тоо		
18	Байгуулсан давхар даатгалын гэрээний тоо		
19	Даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо		
20	Үүнээс: Ипотекийн даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо		
21	Хамгийн өндөр дүнтэй даатгалын гэрээний мэдээлэл:		
22	Даатгуулагч		
23	Даатгалын зүйл		
24	Даатгалын үнэлгээ (төгрөгөөр)		
25	Даатгалын хураамж (төгрөгөөр)		
26	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн мэдээлэл:		
27	Даатгуулагч		
28	Даатгалын зүйл		
29	Даатгалын нөхөн төлбөр (төгрөгөөр)		

30	Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа (хувиар)		
31	Хөрөнгийн хүрэлцээт байдлын байвал зохих доод харьцаа (хувиар)		
32	Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа (хувиар)		
33	Даатгагчийн төлбөрийн чадварын түвшин		

ТАЙЛАН ГАРГАСАН: (албан тушаал) (гарын үсэг) (овог нэр)

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН ХУГАЦАА:оны...сарын... өдөр

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны ... дугаар сарын
...-ны өдрийн ... дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

“Даатгагч болон даатгалын мэргэжлийн
оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх
үзүүлэлт”-ийн 6 дугаар хавсралт (А)

Мэдүүлгийн маягт

1. Даатгуулагчийн мэдээлэл

№	Асуулга	Даатгуулагч (үндсэн зээлдэгч)		Даатгуулагч (хамтран зээлдэгч)	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1	Эцэг (Эх)-ийн нэр:				
2	Нэр:				
3	Иргэний бүртгэлийн дугаар:				
4	Хүйс				
5	Мэргэжил				
6	Утас, цахим хаяг				
7	Оршин суугаа хаяг				
ДООРХ ӨВЧНҮҮДЭЭР ОНОШЛОГДОЖ ЭМЧИЛГЭЭ ХИЙЛГЭЖ БАЙСАН ЭСЭХ		Даатгуулагч (үндсэн зээлдэгч)		Даатгуулагч (хамтран зээлдэгч)	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1	Элэгний В, С, Д вирусийн халдвар илэрсэн, элэгний үйл ажиллагааны хүнд дутагдал, хатуурал				
2	ДОХ-оор өвчилсөн, ХДХВ-ийн халдвар авсан				
3	Судасны цүлхэн, зүрхний титэм судасны нарийсал, зүрхний шигдээс, зүрхний олдмол болон төрөлхийн гажиг, зүрхний дутагдал				
4	Бөөрний түүдгэнцрийн үрэвсэл болон бөөрний дутагдал				
5	Тархины цус багасах дайрлага (ТИА) харвалт, тархины хавдар, уналт таталт, тархины гэмтлээс гаралтай хүндрэлүүд, саа саажилт				
6	Цусны өвчин, хүнд цус багадалт, ясны чөмгөний үрэвсэл, дархлааны тогтолцооны эмгэгүүд болох тогтолцооны чонон яр, хэрлэг төст үений үрэвсэл, тогтолцоот хатуурал				
7	Чихрийн шижин өвчин бай эрхтэнд нөлөөлсөн				

8	Хорт хавдар өвчин				
9	Сэтгэцийн болон зан төрхийн өвчин				
10	Хоол боловсруулах эрхтний архаг хүнд өвчнөөр оношлогдож байсан, эрхтэн тайруулах эсвэл холбох мэс засал хийлгэж байсан (цөсний хүүдий авах, геморрой, шамбарамын хагалгаа, мухар олгой хамаарахгүй)				
11	Согтууруулах ундаа, мансуурах бодис болон эмэнд донтох өвчин				
12	Хүнд хэлбэрийн астма, гуурсан хоолойн архаг бөглөрөлтөт үрэвсэл, архаг сүрьеэ, уушги тайруулсан, мэргэжлийн шалтгаант уушгины архаг өвчин				
13	Удамшлын, төрөлхийн, хромосомын өвчин				
14	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон				

2. Зээлийн мэдээлэл

Зээлийн дүн буюу үлдэгдэл (төгрөгөөр)

Зээлдэгч тус бүрийн даатгалын үнэлгээний хувь (даатгуулагч нарын сонголтоор)

Үндсэн зээлдэгч

Хамтран зээлдэгч

Хамтран зээлдэгч

Зээлийн хугацаа (сараар)

3. Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал

Үндсэн эрсдэл

Нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 (дал) буюу түүнээс дээш хувиар хугацаагүй алдах эрсдэл

Даатгалын эрсдэл учрах шалтгаан, нөхцлийг сонгох (даатгуулагч нарын сонголтоор)

.....

.....

.....

Нэмэлт эрсдэл

.....

Даатгалын компани сонгох

- Урт хугацааны даатгагчийн нэр
- Урт хугацааны даатгагчийн нэр
- Урт хугацааны даатгагчийн нэр

Даатгалын гэрээний хугацаа (жилээр):.....

Даатгалын хураамж төлөх: Сонгох

- Нэг удаа бүрэн төлөх
- Жилээр
- Сараар
- Бусад

МЭДҮҮЛЭГ ГАРГАСАН:

Үндсэн зээлдэгч / /

	Гарын үсэг	Гарын үсгийн тайлал	Огноо
Хамтран зээлдэгч

	Гарын үсэг	Гарын үсгийн тайлал	Огноо
--	------------	---------------------	-------

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт

"Даатгал болон даатгалын маргалийн оролцогчийн санхүүгийн хяналт тайлангийн агуулга, мөнгөт тогтоох журмыг"ын 21 дугаар хавсралт

МАЛТ СХ 04134- ДААТАЛЫН ЗУУЛАГЧ КОМПАНИЙН ОРЛОГЫН ДЭЛЭЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Даатгалын зурчлагчийн нэр: *.....**ХХК

...оны ...сарын ...ны өдөр

№	Үзүүлэлт	Мэрийн дугаар	Зүүлсэн даатгалын үнэлгээ	Түнкис, дэвээр даатгалын үнэлгээ	Зүүлсэн даатгалын хураамжийн орлого	Түнкис, дэвээр даатгалын хураамжийн орлого	Зүүлсэн даатгалын гаржигий тоо			Зүүлсэн дэвээр даатгалын гаржигий тоо	Даатгалын зурчлагчийн шалтгаалийн орлого	Түнкис, дэвээр даатгалын зурчлагчийн шалтгаалийн орлого
							Хувь хүн	Хуулийн этгээд	Үүнд хамрагдсан даатгалын гүйцлийн			
A	B	в	1	2	3	4	5	6	7	8	9	10
1. Сайн дурын даатгал	1.1. Гажигийн өсөл, үнэмлэхгүй зардалын даатгал	1										
	1.1.1. Түнкис: /Илостомийн даатгал	2										
	1.2. Хэрэгсэлийн даатгал	3										
	1.2.1. Түнкис: /Илостомийн даатгал	4										
	1.3. Авто тээврийн хэрэгсэлийн даатгал	5										
	1.4. Ачааны даатгал	6										
	1.5. Барилга угсралтын даатгал	7										
	1.6. Газар тариалангийн даатгал	8										
	1.7. Мал амьлдлын даатгал	9										
	1.7.1. Түнкис: /Малын мэдрэжүүлсэн даатгал	10										
	1.8. Агаарын хөдлийн даатгал	11										
	1.9. Авто тээврийн хэрэгсэлийн жолоочийн хариуцлагын даатгал	12										
	1.10. Хариуцлагын даатгал	13										
	1.11. Энхгүйн даатгал	14										
	1.12. Эвэллийн даатгал	15										
	1.13. Итгэлцэлийн даатгал	16										
	1.14. Төлөөр аажмы болсон усан даамын тэнгэрийн сэрэгсэлийн даатгал	17										
	1.15. Төлөөр аажмы асарт усан даамын тэнгэрийн сэрэгсэлийн өмчлөгч, хамгаалах ажиллагай холбоотой хариуцлагын даатгал	18										
	1.16. Агаарын хөдлийн өмчлөгч, агаарын, ажиллагай холбоотой хариуцлагын даатгал	19										
	1.17. Хувиараг ашигдлагын даатгал	20										
	1.17.1. Түнкис: /Илостомийн даатгал	21										
	1.18. Насан туршийн даатгал	22										
1.18.1. Түнкис: /Илостомийн даатгал	23											
1.19. Хуримтлалын даатгал	24											
1.20. Татварийн даатгал	25											
1.21. Эрүүл мэндийн даатгал	26											
1.22. Ажирлын даатгал	27											
2. Албан журмын даатгал	2.1. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	28										
	Дүн	29										

Малт нэмэх хавсар:

1. Базан *1*-д нийт зүүлсэн даатгалын гаржигий үнэлгэний дүнг бичнэ.
2. Базан *2*-д зүүлсэн дэвээр даатгалын гаржигий үнэлгэний дүнг бичнэ.
3. Базан *3*-д нийт зүүлсэн даатгалын гаржигий даатгалын хураамжийн дүнг бичнэ.
4. Базан *4*-д зүүлсэн дэвээр даатгалын гаржигий хураамжийн дүнг бичнэ.
5. Базан *5*-д хувь хүн, иргэн айл байгуулсан зүүлсэн даатгалын гаржигий тоог бичнэ.
6. Базан *6*-д нэмэгдсэн иргэний хуралд агаарын шалтгаалийг агуулсан эхлэсэн байгуулалтын нэгж, *хуулийн этгээд* айл байгуулсан зүүлсэн даатгалын гаржигий тоог бичнэ. Үүнд дэвээр даатгалын зурчлагчийн тоо хэмжээг олох.
7. Базан *7*-д Базан *6*-д тусгаж хурлийн этгээд айл байгуулсан даатгалын гаржиг хамрагдсан хувь хүн, иргэний тоог бичнэ.
8. Базан *8*-д зүүлсэн дэвээр даатгалын гаржигий тоог бичнэ.
9. Базан *9*-д нийт даатгалын зурчлагчийн шалтгаалийн орлого дүнг бичнэ.
10. Базан *10*-д нийт дэвээр даатгалын зурчлагчийн шалтгаалийн орлого дүнг бичнэ.

томоо тэмдэг

ТАЙЛАНГАРТАСАН:

Гүйцэтгэх захирал /...../ /...../

Брэнчийн өмчлөгч /...../ /...../

..... /...../ /...../

Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны ... дугаар сарын
...-ны өдрийн ... дүгээр тогтоолын тавдугаар хавсралт

*Даатгачийн давхар даатгалын төлөвлөгөөнд
тавигдах шаардлага*-ын 1 дүгээр хавсралт

МАЯГТ СЗХ04153.ФАКУЛЬТАТИВ ДАВХАР ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Даатгачийн нэр:

..... оны сарын ...-ны өдөр

№	Гэрээ эхэлсэн огноо	Гэрээ дуусах огноо	Даатгалын гэрээний дугаар	Даатгалын бүтээгдэхүүн	Даатгалын үнэтгээ	Даатгалын хураамж	Давхар даатгалын хураамж	Даатгалын зуучлагчаар дамжсан эсэх*				Давхар даатгач		Давхар даатгалын нөхцөл**		Эрсдэлийн хувь***		Хариуцлагын хягаар****		Шимтгэл Commission/	Давхар даатгалд ногдох нөөц сангийн хэмжээ	Нийт нөхөн төлбөр	Үүнээс: Давхар даатгачаас төлсөн нөхөн төлбөр				
								Шууд	Дотоодын зуучлагч	Гадаадын зуучлагч		Оноосон нэр	Харьяалагдах улс	Хувь тэнцүүлсэн /proportional/	Хувь /non-proportional/	Даатгач хариуцах хувь	Давхар даатгач хариуцах хувь	Даатгач хариуцах дээд хэмжээ	Давхар даатгач хариуцах дээд хэмжээ								
										Оноосон нэр	Харьяалагдах улс													quota share	surplus share	Stop loss	Excess of loss
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26		
Нийт																											
1																											
...																											
100																											

Маягт нөхөх заавар:

* Даатгалын зуучлагчаар дамжсан эсэх- даатгалын зуучлагчаар дамжуулсан тохиолдол зуучлагч компанийн нэрийг бичих; Даатгач давхар даатгачтай шууд гэрээ байгуулсан тохиолдолд багана 8 ("шууд")-г сонгох

** Давхар даатгалын нөхцөл- давхар даатгалын гэрээний нөхцөлийг сонгох

***Эрсдэлийн хувь хэмжээ- Давхар даатгачтай quota share, surplus share нөхцөлөөр гэрээг хийсэн тохиолдолд даатгач болон давхар даатгачид хариуцах хувь хэмжээ (багана 19, 20)-г бөглөх. Хэрэв хэл хэлдэн давхар даатгач оролцох тохиолдолд хариуцах хэмжээг тус бүрээр мөр нэмэх.

****Хариуцлагын хягаар- Давхар даатгачтай stop loss, excess of loss нөхцөлөөр давхар даатгалын гэрээг хийсэн нөхцөлд даатгач, давхар даатгачийн хариуцлагын дээд хягаарын хэмжээ (багана 21, 22)-г бичих

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал /...../ /...../

Ерөнхий нягтлан бс /...../ /...../

..... /...../ /...../

МАЯГТ СЗХ04154.ГЭРЭЭТ ДАВХАР ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Даатгачийн нэр:

.... оны сарынны өдөр

№	Гэрээ эхэлсэн огноо	Гэрээ дуусах огноо	Даатгалын бүтээгдэхүүн	Нийт үнэлгээ	Давхар даатгалын хураамжийн төлөх нөхцөл		Даатгалын хураамжийн дүн		Давхар даатгач компанийн нэр		Даатгалын зуучлагчаар дамжсан эсэх*		Даатгалын шимтгэлийн нөхцөл**			Даатгалын нөхцөл***					Эрсдэл хариуцах		Хариуцлагын хэмжээ*****		Нөхөн төлбөрийн дүн		Давхар даатгалд ногдох нөөц сангийн хэмжээ		
					Нэг удаа төлөх	Тухай бүр төлөх	Нийт хураамж	Давхар даатгалын хураамж	Оноосон нэр	Харьяалагдах улс	Шууд	Дотоодын зуучлагч	Оноосон нэр	Харьяалагдах улс	Sliding scale/	Loss corridors/	Profit commission/	pro-rata/		non-proportional/			Даатгач	Давхар даатгач	Даатгач хариуцах дээд хэмжээ	Давхар даатгач хариуцах дээд хэмжээ		Нийт нөхөн төлбөр	Давхар даатгачаас төлсөн нөхөн төлбөр
																		quota share	surplus share	Stop loss	Excess of loss	catch-up loss							
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30
Нийт					-		-	-																	-	-	-	-	-
1																													
...																													
50																													

* Даатгалын зуучлагчаар дамжсан эсэх- даатгалын зуучлагчаар дамжуулсан тохиолдолд зуучлагч компанийн нэрийг бичих; Даатгач давхар даатгачтай шууд гэрээ байгуулсан тохиолдолд багана 9 ("шууд")-г сонгох
 ** Даатгалын шимтгэлийн нөхцөл- Хэрэв даатгач шууд давхар даатгалын компанитай гэрээ байгуулсан тохиолдолд тохирох баганад нийт шимтгэлийн хэмжээг бичих
 *** Давхар даатгалын нөхцөл- давхар даатгалын гэрээний нөхцөлийг сонгох
 **** Эрсдэлийн хариуцах хувь- Давхар даатгалыг "quota share", "surplus share" нөхцөлөөр хийсэн тохиолдолд "эрсдэлийн хариуцах хувь" (багана 19,20) -г харгалзан бөглөнө.
 ***** Хариуцлагын хэмжээ- Давхар даатгалыг "stop loss", "excess of loss" нөхцөлөөр хийсэн тохиолдолд " хариуцлагын хэмжээ"(багана24,25)-г харгалзан бөглөнө
 ***** Нийт дүн- тайлант хугацаа түс бүрийн нийт дүнг гаргана.

тамга тэмдэг

ТАЙЛАН ГАРГАСАН:

Гүйцэтгэх захирал

Ерөнхий нягтлан бодогч

.....